

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЗӨВЛӨЛ ҮНДСЭН ЧИГ
ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА”

АУДИТЫН КОД: АГГ-2022/20-ШТА-ГА

Дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар	
Утас: 88883317	Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер Б.Тэгшдэлгэр	
Утас: 99089114	Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Отгонбаяр	
Утас: 89306788	Цахим хаяг: otgonbayar.de@audit.gov.mn
Аудитор Н.Гүрбазар	
Утас: 92118084	Цахим хаяг: gurbazarn@audit.gov.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
khuvsgul.audit.mn/state/16 цахим хуудаснаас авна уу.

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь Төрийн
аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

Д.Отгонбаяр

Аудитор

Н.Гүрбазар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3 давхар

Цахим хаяг:

audit.mn/?page_id=579

2022 оны 5 дугаар сар

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий мэдээлэл

**БҮЛЭГ 1. АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ЗӨВЛӨЛ ҮНДСЭН ЧИГ ҮҮРГЭЭ БҮРЭН
ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.**

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хэдий ч санхүүжилтийн эх үүсвэрийн тухайд харилцан уялдаагүй, хэрэгжилт хангалтгүй байна.

1.2. ХЭДС-ийн төсвийн хуваарийг хийхдээ газар нутгийн байршил, хүн амын тоог харгалзахгүйгээр төлөвлөсөн байна.

1.3. Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

**БҮЛЭГ 2. ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ
ДЭМЖИХ, АЖИЛГҮЙДЛИЙГ БУУРУУЛАХ, АЖЛЫН
БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР
ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ТОДОРХОЙ ҮР
ДҮНД ХҮРСЭН БАЙНА.**

2.1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний тоон мэдээлэл бодитой бус, үр нөлөөг үнэлэх боломжгүй байна.

2.2. Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангаас хөнгөлөлттэй зээлд хамрагдаж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд нь байнгын болон түр ажлын байрыг бий болгох, үйлдвэржилтийг дэмжих гэсэн үндсэн зорилтуудыг хангаагүй, үр дүн тооцоогүй байна

2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-ийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төлөвлөөгүй байна.

2.4. Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаа үр нөлөөтэй хэрэгжсэн байна.

2.5. Цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь иргэд, аж ахуйн нэгжид тодорхой дэмжлэг болсон байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НҮБ	Нэгдсэн Үндэсний байгууллага
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
СХС	Сум хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ОНТС	Орон нутгийн тусгай сан
УОНТ	Улс орон нутгийн төсөв
ОУБЗТ	Олон улсын байгууллагын зээл тусламж
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ЖДҮХС	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан
ЖДҮХОНТС	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх орон нутгийн тусгай сан
ХШҮ	Хяналт, шинжилгээ үнэлгээ
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
ӨГҮДС	Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан
ҮДС	Үйлдвэржилтийг дэмжих сан
МСҮТ	Мэргэжлийн боловсрол сургалтын төв



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/08.

Мөрөн сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2018 оны А/207 “Эрх үүрэг шилжүүлэх тухай” дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын газрын гуравдугаар газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Хүнс хөдөө, аж ахуйн газар, Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дээрх байгууллагын дарга нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор /Д.Отгонбаяр/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын хэлтсийн дарга, аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-т даалгасугай.

6. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /ахлах аудитор Д.Отгонбаяр/-т үүрэг болгосугай.



А.ЭРДЭНЭБААТАР

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт:

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг ҮАГ-т танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийнэ. Үүнд:

- Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг мөн төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх,
- Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байгаа эсэх

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд МУЗГ-ын 2016 оны 320 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын баримт бичиг”-т тусгасан төсөл, хөтөлбөр зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах, үнэлж дүгнэх үүрэг хүлээсэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл, сум, баг, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтны 2016-2021 оны үйл ажиллагаа, сумдын сум хөгжүүлэх сангийн 2016-2021-ны үйл ажиллагаа, ажлын байр нэмэгдүүлэх чиг үүрэг бүхий бусад сан болон бусад холбогдох байгууллагын үйл ажиллагааг хамрууллаа. /Тариалан, Их-Уул, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Галт, Жаргалант, Шинэ-Идэр, Түнэл, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Мөрөн сумдыг түүвэрлэн хамрууллаа./

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 3000-3100, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим” MNS6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх арга зүйг ашиглана.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлд

Аудитад дараах хууль тогтоомж, эрх зүйн актыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 4-26 дугаар зүйл
- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

Улсын Их Хурлын тогтоол

- УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”
- УИХ-ын 2016 оны 320 дугаар тогтоол “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”
- УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол “МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”

Засгийн газрын тогтоол

- МУЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- МУЗГ-ын 2011 оны 375 дугаар тогтоол “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”
- МУЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоол “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”
- МУЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- МУЗГ-ын 2020 оны 113 дугаар тогтоол “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”

Аймгийн ИХТ-ын тогтоол

- Аймгийн ИТХ-ын 2015 оны 02 дугаар тогтоол “Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх хөтөлбөр”
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр /2016-2020/
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр /2021-2024/
- Аймгийн ИТХ-ын 2016 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан”
- Аймгийн ИТХ-ын 2018 оны 150 дугаар тогтоолоор баталсан “Жимс жимсгэнэ” дэд хөтөлбөр
- Аймгийн ИТХ-ын 2018 оны 151 дүгээр тогтоолоор баталсан “Хүнсний ногоо” дэд хөтөлбөр
- Аймгийн ИТХ-ын 2020 оны 91 дүгээр тогтоолоор баталсан “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх” дэд хөтөлбөр
- Аймгийн ИТХ-ын 2020 оны 92 дугаар тогтоолоор баталсан “Хоршоо хөгжүүлэх” дэд хөтөлбөр
- Аймгийн ИТХ-ын 2020 оны 93 дугаар тогтоолоор баталсан “Жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх” дэд хөтөлбөр

Ерөнхий мэдээлэл:

Хөвсгөл аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой чиг үүргийг хариуцан хэрэгжүүлэх байгууллага болох аймгийн Хөдөлмөрийн хэлтэс гэсэн бүтэц зохион байгуулалтаас МУЗГ-ын 2016 оны 9 дүгээр тогтоолоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болон өөрчлөгдөн зохион байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн чиглэлийн бодлогыг хэрэгжүүлэгч агентлаг нь ХХҮГ байна. Тус газар нь Хөдөлмөрийн хэлтэс, Халамжийн хэлтэс, захиргаа хяналтын хэлтэс гэсэн бүтэц зохион байгуулалттай байна. Хөдөлмөрийн хэлтэс нь 6, сумдад 28 нийт 34 албан хаагч ажиллаж байна.

Аймгийн Статистикийн хэлтэс нь ХХҮГ-аас хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тоон мэдээллийг эх сурвалж болгон олон нийтэд мэдээлж байна.


ХХҮГ нь LMIS программ дээр ажилгүй иргэн, ажил идэвхтэй хайгч иргэн, ажил олгогчийн бүртгэлийг хөтөлж байна.

Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх үндсэн зорилт бүхий ХЭДС, СХС, ЖДҮХС, ОНТС / Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан, Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан /-ийн хөрөнгөөр хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Сангуудаас 2016-2021 онд зарцуулсан хөрөнгийн эзлэх хувийг диаграммаар харуулбал: Диаграмм №1



ХЭДС-ийн хөрөнгийг аймгийн ХХҮГ Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ыг баримтлан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр жил бүр ажлын байрыг дэмжих, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ХБИ-ний ажлын байрыг дэмжих зэрэг 5-н хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлсэн байна. Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ХХҮЕГ-аас санхүүжилтийг дараах байдлаар хуваарилсан байна.



БҮЛЭГ 1. АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЗӨВЛӨЛ ҮНДСЭН ЧИГ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хэдий ч хэрэгжилт хангалтгүй байна.

Төрөөс хэрэгжүүлж байгаа бодлогын хүрээнд Хөвсгөл аймгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхээр 34-н зорилт, 92 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №1

№	Бодлогын баримт бичиг	Дэвшүүлсэн зорилт	Арга хэмжээ	Санхүүжилт	
				Эх үүсвэр	Дүн /сая.төг/
Урт хугацааны бодлого					
1	Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх хөтөлбөр	4	12	-	0
Дунд хугацааны бодлого					
2	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр /2016-2020/	6	24	УОНТ	-
3	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр /2021-2024/	13	22	УОНТ	1,094.9
Богино хугацааны бодлого					
4	Аймгийн “Үндсэн чиглэл” 2016	1	3	ОНТ	100.0
5	Аймгийн “Үндсэн чиглэл” 2017	1	2	ОНТ	90.0
6	Аймгийн “Үндсэн чиглэл” 2018	1	2	УТ	98.0
7	Аймгийн “Үндсэн чиглэл” 2019	2	2	ОНТ, Бусад	2050.0
8	Аймгийн “Үндсэн чиглэл” 2020	1	1	-	0
Аймгийн дэд хөтөлбөр					
9	“Жимс жимсгэнэ” дэд хөтөлбөр	1	4	УОНТ, ОУБЗТ	15.0
10	“Хүнсний ногоо” дэд хөтөлбөр	1	3	УОНТ, ОУБЗТ	10.0
11	“Жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх” дэд хөтөлбөр	1	7	УОНТ, ЗГТС, ОУБЗТ	0
12	“Хоршоо хөгжүүлэх” дэд хөтөлбөр	1	4	УОНТ, ЗГТС, ОНХС, СХС-с	0
13	“Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх” дэд хөтөлбөр	1	6	УОНТ, ЗГТС, ОНХС, СХС, ОУБЗТ	0
Нийт		34	92		3,462.9

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх дээрх зорилт арга хэмжээнд 3,462.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсний 3,030.0 сая төгрөг буюу санхүүжилтийн эх үүсвэрийн 87% нь ХЭДС-аас олгох санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэр байна.

Аймгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгасан зорилт арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй шалтгаан нөхцөл. **Үүнд:**

- Дэд хөтөлбөрт туссан арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг ЖДҮДС, ОНХС, СХС, ХЭДС-аас зарцуулахаар төлөвлөсөн.

Засгийн газрын тусгай сан буюу ХЭДС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөр арга хэмжээнүүд нь тухайн он тус бүртээ батлагдсан хөрөнгийн хүрээнд гүйцэтгэлийг хангаж ажилласан байна.

Харин орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан дэд хөтөлбөрүүдийн хувьд санхүүжилтийн эх үүсвэрийг нь тухай бүрд шийдвэрлэж, төсөвт тусгаж батлаагүйгээс бүрэн хэрэгжих боломжгүй болсон байна.

Аймгийн хэмжээний хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг үнэн зөв тодорхойлох боломжгүй, тодорхойлж гаргасан индекс, тоон үзүүлэлтүүд нь зөрүүтэй байгаагаас бодлого тодорхойлоход сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг буюу идэвхтэй ажил хайж байгаа иргэн, ажлын байрны захилга, ажилд зуучлагдсан иргэдийн тоон мэдээллийг 2017-2019 оноор нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 2

№	Эрэлт, хэрэгцээ	2017 он			2018 он			2019 он		
		Статистик	ХХҮГ	Зөрүү	Статистик	ХХҮГ	Зөрүү	Статистик	ХХҮГ	Зөрүү
1	Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй ажил хайгч	909	909	0	1483	1483	0	1367	1479	112
2	Ажлын байрны захиалга	1754	1754	0	1860	1860	0	664	1275	611
3	Ажилд зуучилсан тоо	1406	1406	0	1575	1575	0	487	1236	749
4	Нийт	4069	4069	0	4918	4918	0	2518	3990	1472

Эх сурвалж: “Хөвсгөл аймгийн нийгэм эдийн засгийн байдал”-ын эмхэтгэл, Хөвсгөл ХХҮГ-ийн LMS систем

Дээрх хүснэгтээс харахад аймгийн ХХҮГ-ийн мэдээлэл, Статистикийн хэлтсээс бэлтгэн гаргасан мэдээллүүд нь 2017, 2018 онууд зөрүүгүй байгаа боловч 2019 онд нийт 1472-оор зөрүүтэй мэдээлсэн байна.

Хөвсгөл аймаг 2016-2020 онд Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлсон нэгдсэн судалгаагүй, мэдээллийн сан үүсгээгүй, эрэлт хэрэгцээтэй байгаа мэргэжил, илүүдэлтэй байгаа ажилтны тоог гаргаагүй байна.

Аймгийн ХХҮГ болон статистикийн хэлтэс, МСҮТ болон бусад төрийн байгууллагуудаас хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлсон судалгаа мэдээллийг хийсэн нотлох баримтгүй байна.

Харин 2021 оноос Хөдөлмөрийн зах зээлийн судалгаатай болсон бөгөөд тус судалгааг үндэслэн Хөвсгөл аймаг 2022 оныг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгон зарлаж тодорхой ажлуудыг зохион байгуулж эхэлсэн үзүүлэлттэй байна.

Судалгаа мэдээлэл хангалтгүй, хариуцсан төрийн байгууллагаас гаргасан мэдээллүүд зөрүүтэй байгаагаас харахад хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг үнэн зөв тодорхойлох боломжгүй, тодорхойлж гаргасан индекс, тоон үзүүлэлтүүд нь бодлого тодорхойлоход сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Бодлогын баримт бичгийг боловсруулахад талуудын оролцоог хангаж ажилласан байна.

Хөвсгөл аймаг 2016-2021 онд Хөвсгөл аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр аймгийн дэд хөтөлбөрүүдийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан байна.

Урт хугацааны хөгжлийн бодлогоо тодорхойлохын тулд эрдэмтэн, судлаачид, иргэд олон нийтийн саналыг тусгах зорилгоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 49 дүгээр тогтоолоор “Хөвсгөл Хөгжил” -2 форум зохион байгуулах шийдвэр гарсан байна. Түүнийг үндэслэн аймгийн Засаг даргын 2015 оны А/272 дугаар захирамжаар дээрх үйл ажиллагааг зохион байгуулах салбар хороог 16 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Үүнд: Аймгийн ХХҮГ-ын хөдөлмөрийн хэлтэс, ХХААГ, Статистик, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ зэрэг төрийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан ажлын хэсэг байгуулснаас харахад бодлого хэрэгжүүлэх талуудын оролцоог хангасан байна.

Хөтөлбөр боловсруулахад дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- ✚ Иргэдийн санал бодлыг тусгахын тулд жилд 2-оош доошгүй удаа сум, багууд дээр ажиллаж тэдний саналыг тусгай маягтаар, амаар, бичгээр авч, байнгын утас ажиллуулсан.
- ✚ Салбар тус бүрийн мэргэжилтнүүд, төрийн бус байгууллагуудаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- ✚ 2015 оны үзүүлэлтүүдийг суурь үзүүлэлт болгон авч аймгийн хөгжлийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлсэн
- ✚ Хөвсгөл аймгийн өнөөгийн давуу болон сул талуудыг тооцон, хөгжлийн боломж ба эрсдэлийг судалсан.
- ✚ Хөвсгөл аймгийн алсын хараа, хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон байна.

Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах явцдаа байнгын хороо, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 3 удаа, ИТХ-ийн Тэргүүлэгчдийн Хурлаар 2 удаа хэлэлцүүлсэн байна.

Харин үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрийг боловсруулахдаа тухайн зорилт арга хэмжээг хариуцан гүйцэтгэх байгууллагын саналыг авч тусгаагүй байгаа нь талуудын оролцоог хангасан байна.

1.2. ХЭДС-ийн төсвийн хуваарийг хийхдээ газар нутгийн байршил, хүн амын тоог харгалзахгүйгээр төлөвлөсөн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх, дэмжих үйл ажиллагааны хүрээнд аймагт дараах тусгай сан, төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Үүнд:

1. ХЭДС нь Засгийн газрын тусгай сан учраас жил бүр улсын төсвөөс хөрөнгө хуваарилан төлөвлөж хэрэгжүүлж байна.
2. ЖДҮХС-гууд нь Засгийн газрын тусгай сан боловч аймаг тухайн жилд зарцуулах хөрөнгийн дүнг төлөвлөөгүй байна.
3. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн сумын төсвийн төвлөрүүлэн захирагч бүр тухайн сумын төсөвт төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.
4. Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих, үйлдвэржилтийг дэмжих сангийн тухайд аймгийн ТЭЗ буюу Засаг дарга арилжааны банктэй гэрээ байгуулан ажиллаж байгаа ба төсөвт төлөвлөж хэрэгжүүлээгүй байна.

Улсын төсвөөр хэрэгжүүлж байгаа ХЭДС сангийн төлөвлөлтийг он тус бүрээр харуулбал дараах байдалтай байна. Хүснэгт №2 /сая төгрөгөөр/

№	Тусгай сангийн нэр	Санал	Төлөвлөгөө	Зөрүү
1	2018	3,206.5	1,413.2	1,793.3
2	2019	3,261.2	1,802.4	1,458.8
3	2020	1,964.3	1,133.2	831.1
4	2021	1,837.8	867.9	969.9

Хүснэгтээс харахад: Жил бүрийн хүргүүлсэн төсвийн саналыг бууруулж баталсан байна.

ХЭДС-ийн төсвийн хуваарийг хийхдээ газар нутгийн байршил, хүн амын тоог харгалзахгүйгээр төлөвлөсөн байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газраас ХЭДС-ийн төсвийн хуваарийг хийж баталгаажуулсан байдлыг бусад аймагтай харьцуулан үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгтээр харуулбал: Хүснэгт №3

№	Аймаг	Газар нутгийн байршил	Хүн амын тоо	ХЭДС-аас хуваарилсан хөрөнгө /2022 оны байдлаар/
1	Говьсүмбэр	УБ-аас	17,965	2,252.7 сая
2	Хөвсгөл	УБ-аас 700 орчим	135,705	2,252.7 сая
3	Хэнтий	УБ-аас 320 орчим	78,172	2,252.7 сая

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газраас аймаг бүрд ХЭДС-ийн төсвийн хуваарийг хийхдээ газар нутгийн байршил, хүн амын тоог харгалзахгүйгээр төлөвлөсөн байна.

Хөвсгөл аймагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэхээр 2016-2021 онуудад аймгийн ЗДҮАХ-т зорилт арга хэмжээний хүрээнд батлагдсан дэд хөтөлбөрүүдийг аймгийн ОНХО, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тус тус төлөвлөсөн байна. Санхүүжилтийн эх үүсвэрийн төлөвлөлтийг хүснэгтээр харуулбал: Хүснэгт №4

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Эх үүсвэр	Төлөвлөгөө /2016-2021 сая төгрөг/	Тайлбар
1	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	ОНХО	285.0	-
2	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	ОНХС	327.0	-

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан нь Төсвийн тухай хууль 60.3.6 дахь заалт болон, ОНХС-ийн журамд заасан иргэдийн саналаар дэмжигдэж, эрэмбэлэгдсэн байх шалгуурыг хангаагүй ТАХ-г хууль журам зөрчиж хэрэгжүүлэх нөхцөл үүсэж байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ нь тухайн жилдээ иргэдийн саналаар дэмжигдэж ИНХ-аар хэлэлцүүлэн баг, сумын Засаг даргаас сум, аймгийн ИТХ-д хүргүүлэн батлуулж хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл заасан байдаг тул иргэд тухайн хөтөлбөр арга хэмжээнд санал өгөхгүй бол хууль, журам зөрчих нөхцөл бүрдэж байна.

ХЭДС, СХС-аас олгож байгаа хөрөнгийн эх үүсвэр нь иргэн аж ахуйн нэгжийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байгаагаас үр дүнтэй хэрэгжихгүй байгаа нэг шалтгаан болсон байна.

Хөвсгөл аймгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг болон Засгийн газраас хэрэгжүүлсэн үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр боловсруулж баталсан дэд хөтөлбөрүүдийн санхүүгийн эх үүсвэрийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр дэд хөтөлбөр тус бүрд баталсан боловч, орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилаагүй байна.

Санхүүгийн эх үүсвэрийг тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх цаг үед нь баталж өгөөгүйгээс дэд хөтөлбөрүүдийг бүрэн хэрэгжүүлж, төлөвлөсөн үр дүнг гаргаж чадаагүй байна.

Аймгийн ХЭДС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийг сонгон шалгаруулах явцад санхүүгийн эх үүсвэрийн дүнг бууруулж баталснаас тухайн төсөл хөтөлбөрийн үр дүнг бууруулж, нөгөө талаас орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, бодитой тоо судалгаанд үндэслэн санхүүгийн эх үүсвэрийг баталж ирүүлээгүй байгаатай холбоотой гэж аудитаар үзэж байна. **Тухайлбал:** Аудитаар ажилласан суманд түүвэр хяналтыг хэрэгжүүлэхэд ХЭДС-ийн хөрөнгөөр олгосон зээлийг хүссэн дүнтэй харьцуулбал дараах байдалтай байна. *Хүснэгт №5 /сая төгрөг/*

Он	Хүссэн зээлийн дүн	Олгосон зээл	Зөрүү
Мөрөн сум			
2017	361.5	298.2	63.3
2018	1,102.0	1,050.5	51.5
2019	621.0	508.4	112.6
2020	477.0	366.0	111.0
2021	257.0	228.0	29.0
Галт сум			
2018	3.0	1.0	2.0
2018	5.0	3.0	2.0
Төмөрбулаг сум			
2018	5.0	2.5	2.5
2018	5.0	1.5	3.5
2020	5.0	3.0	2.0

Хүснэгтээс харахад: ХЭДС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд ирүүлсэн төсөл арга хэмжээний санхүүгийн дэмжлэг хүссэн дүнг олгохоор шийдвэрлэсэн дүнтэй харьцуулахад бууруулж олгосон байна.

Сум хөгжүүлэх сангаас олгож байгаа зээлийн хувьд ч дээрх зөрчил давтагдаж байна. *Хүснэгт №6 /сая төгрөг/*

Он	Зээл хүссэн дүн	Зээл олгосон дүн	Зөрүү
2016	258.0	218.0	40.0
2017		Олгоогүй	
2018	671.3	434.5	236.8
2019		Олгоогүй	
2020	800.4	400.0	400.4
2021	541.6	350.0	191.6

Мөрөн сумын СХС-ийн зээл

зээлийг хүссэн боловч 10.0 сая төгрөгийг олгосноор төлөвлөсөн үр дүнд хүрч чадаагүй, зориулалт бусаар зарцуулсан, зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

Сумын ИТХ, ИТХ-ын зээлийн хяналтын хорооноос Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хэрэгжилт, зарцуулалтад хяналт тавьж ажилладаг ч зээлийг зориулалт бусаар ашиглаж буйд тавих хяналт сул байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгосон зээлийн 1,703.3 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл, ХЭДС-ийн хөрөнгөөр олгосон 740.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн санхүү дэмжлэгийн үлдэгдэл тус тус санхүүгийн тайланд тусгагдсан байна. Энэ нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Иргэн, аж ахуйн нэгжид сум хөгжүүлэх сан, ХЭДС-ийн хөрөнгөөр олгож байгаа зээлийн хэмжээ бага, ажлын байр нэмэгдүүлж, бизнес эрхлэх эх үүсвэр болж чадахгүй байгаагаас зээлийн эргэн төлөлт удаашралтай байна.
- Нөгөө талаас арилжааны банкны зээлийн хүү хэт өндөр байгаагаас иргэд сум хөгжүүлэх сангаас янз бүрийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр төсөл бичиж зээл авч байгаа ч бодит байдал дээр өрхийн хэрэгцээнд зарцуулж байна.
- Зээл олгох “Зөвлөл”-өөр шаардлага хангасан төсөл арга хэмжээг санхүүжүүлээгүй, сонгон шалгаруулалтыг журам зааврын дагуу хийхгүй байгаагаас зээлийн эргэн төлөлт удааширч, эзэн холбогдогчгүй болох гэх мэт асуудлууд үүсэж байна.

1.3. АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЗӨВЛӨЛ ҮНДСЭН ЧИГ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь чиг үүргээ бүрэн хэрэгжүүлснээр төрийн байгууллагуудын уялдаа холбоо сайжирч аймгийн ЗД буюу ТЕЗ мэдээллээр хангагдаж бодлого нэгдмэл байх нөхцөл бүрдэхээр байна.

Хөвсгөл аймагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиг үүргийг аймгийн ХХҮГ, аймгийн ЗДТГ-ын бүтцийн нэгж НБХ, ХБТХОХ болон, аймгийн МСҮТ, ХХААГ зэрэг байгууллагууд хэрэгжүүлж байна. Хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээг харуулбал:

Хүснэгт №7

№	Байгууллага	Хэрэгжүүлж буй чиг үүрэг	Санхүүжилтийн эх үүсвэр	Уялдсан байдал
1	Аймгийн ЗДТГ-ын НБХ	-ЗГ-аас гарсан бодлого, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах хамтран зохион байгуулдаг, -ХХҮГ-аас ажлын байрны мэдээ тайлан авдаг,	АЗДТГ-ын төсөв	Газар, хэлтсээс тайлан авч нэгтгэдэг.
2	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ	-Аймгийн ЖДҮ-ийг дэмжих сангаас олгох зээлийн төслийг хүлээн авч сонгон шалгаруулах, яаманд шалгарсан төслийг хэрэгжүүлэх эрэмбийн саналыг хүргүүлдэг, -Аймгийн ИТХ-аас 2016 оны 20-р тогтоолоор баталсан журмыг баримтлах,	-Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан -Өрхийн үйлдвэржилтийг дэмжих сан	Зээл олгох тэргүүлэх чиглэл байхгүй.
3	ХХҮГ	-Аймгийн ХЭДС-д хуваарилагдсан хөрөнгийг хууль журамд заасны дагуу зарцуулж Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг зохион байгуулж байна. -Хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг олгох, жижиг зээл олгох чиг үүргийг аймгийн ХХҮГ-аас бие даан шийдвэрлэдэг.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	ХХҮГ нь ХХҮЕГ-аас баталсан удирдамжийн дагуу хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.
4	ХХААГ	Зээл олголтыг сум суманд зохион байгуулж, зээлийн нэгдсэн дүн судалгаа ХХААГ-т нэгтгэгддэг.	Сум хөгжүүлэх сан	Зээл олгох тэргүүлэх чиглэл байхгүй
5	МСҮТ	МСҮТ нь 20 орчим чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байна.	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн санхүүжилт	-Аймгийн ЗДТГ-ын НБХ-тэй хамтарч ажилладаг. -Харин БСУГ, ХХҮГ-аас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр удирдлага арга зүйгээр хангаж хамтран ажилладаггүй.

Хөвсгөл аймагт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиг үүрэг хэрэгжүүлэх байгууллагууд байгаа хэдий ч сангуудаас олгож буй хөнгөлөлттэй зээлээр аль салбарт хэдэн ажлын байр бий болгох, хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлоогүй байна.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг газар, хэлтэс болон ЗДТГ бусад нэгжүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

ХЭДС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд бий болсон ажлын байрны мэдээлэл бүртгэгдэж байгаа боловч СХС, ОНТС-аас бий болсон ажлын байрны мэдээллийг нэгдсэн байдлаар албажуулан хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад нэгтгэгдэхгүй байна. Үүнийг аймгийн НБХ нь бодлого арга зүйгээр хангаж ХЭЗ нь удирдан чиглүүлж ажиллах нь зүйтэй байна.

Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслүүд үр дүн муутай байна.

Аймгийн урт хугацааны бодлогод үйлдвэржилтийг дэмжих чиглэлээр урт хугацааны бодлогод тусгасан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхээр Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан, аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангуудаар дамжуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгохоор иргэн, аж ахуй нэгжээс ирүүлсэн төсөлд хөнгөлөлттэй зээлийг олгож байна.

Сангуудын хөрөнгийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 20 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх захиран зарцуулах, хяналт тавих журам”-аар баримтлан зарцуулах зохицуулалттай байна.

Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сангийн тухайд: Монгол Улсын 2009 оны Төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд “Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан” төслийг хэрэгжүүлэхээр 400.0 сая төгрөг батлагдсан байна. Энэхүү хөрөнгийг Мөрөн суманд 80.0 сая төгрөг, Хатгал тосгонд 12.0 сая төгрөг, бусад сум бүрд 14.0 сая төгрөг олгохоор хуваарилсан.

ХААН банкт байгуулсан гэрээний 2.4.1-2.4.3-д зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээг 10.0 сая төгрөг, зээлийн хүүг жилийн 7%, зээлийн хугацаа 24 сар байхаар тогтоон мөрдөж байна. Зээл олголт, олгосон зээлийн хүрээнд бий болсон байнгын болон түр ажлын байр дараах байдалтай байна.

Хүснэгт № 8

Он	Төсөлд хамрагдсан өрхийн тоо	Олгосон зээлийн эхний үлдэгдэл	Тухайн онд олгосон зээлийн дүн	Эргэн төлөлт	Олгосон зээлийн эцсийн үлдэгдэл 2021.12.31-өдрөөр	Шинээр ажлын байр	
						Байнга	Түр
2016	51	240.9	179.2	223.1	284.8	51	-
2017	76	284.8	357.8	225.6	152.6	76	25
2018	34	152.6	188.0	210.3	274.9	34	15
2019	46	174.9	184.7	132.2	122.4	46	10
2020	26	122.4	116.7	88.6	94.3	26	9
2021	12	94.3	90.7	91	94.6	12	-
ДҮН		Нийт 24 сумын 245 өрхөд 1,117.1 сая төгрөгийн зээл олгосон байна.				245	59

Тус сангаас 24-н суманд 245 байнгын, 59-н түр ажлын байр бий болсноос харахад ажлын байр бий болгох, хадгалах үр дүнд хүрсэн байна.

Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангийн тухайд: Тус сангийн эх үүсвэр нь “Лидер Кашмир” ХХК-д 2009 онд тоног төхөөрөмж худалдан авах зорилгоор олгосон зээлийн төлөгдөөгүй байсан үлдэгдлийг “Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан”-ийн ХААН банк дахь дансанд төвлөрүүлснээр бий болсон байна.

2017 оны 12 сарын 07 өдрийн гэрээгээр 155.0 сая төгрөгийн сан бүхий бүс орон нутгийн хөгжлийг дэмжих сан, 510.7 сая төгрөгийн сан бүхий аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангуудыг нэгтгэн **665.7** сая төгрөгийн сан бүхий “Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан” болгосон байна.

Аймгийн хэмжээнд 2016-2021 оны байдлаар 11 сумын 32 иргэн, аж ахуйн нэгж үйлдвэржилтийг дэмжих зээлд хамрагдаж, 13-н сум зээлд огт хамрагдаагүй байна. **Тухайлбал:** Алаг-Эрдэнэ, Арбулаг, Баянзүрх, Бүрэнтогтох, Их-уул, Рашаант, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Улаан-уул, Ханх, Хатгал, Шинэ-идэр, Эрдэнэбулган/

Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангийн зээл авсан зээлдэгчийн 65.6% буюу 21-н зээлдэгч нь Мөрөн сумын иргэн, аж ахуй нэгж байгаа нь мэдээлэлтэй иргэд зээлд хамрагдаж байгааг харуулж байна.

Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангаас зээл авах иргэн, аж ахуй нэгжийг төслөө ирүүлэх талаарх мэдээллийг ил, тод мэдээлж оролцох боломжоор хангаж, төсөл сонгон шалгаруулсан үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлж ажиллах нь зүйтэй байна.

Үйлдвэржилтийг дэмжих сангаас 2016-2021 онд 9 аж ахуй нэгж 463.0 сая, 23 иргэнд 785.1 сая төгрөг нийт 1,248.1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна.

Хүснэгт № 9 /дүн сая төгрөгөөр/

№	Төрөл	2016		2017		2018		2019		2020		2021		Бий болсон ажлын байр	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	Байнга	Түр
1	ААН	2	48	1	60	2	100	2	170	2	85	0	0	48	49
2	Иргэн	6	207	1	7.1	7	230	2	105	5	165	2	71		
Нийт		8	255	2	67.1	9	330	4	275	7	250	2	71		

Үйлдвэржилтийг дэмжих сангаас 2016-2021 онд төсөл сонгон шалгаруулж олгосон зээлийн хүрээнд 48-н байнгын ажлын байр бий болсон байгаа нь өрхийн үйлдвэрлэлийг дэмжих сангаар олгосон зээлийн хүрээнд 245-н байнгын ажлын байр бий болсон тоотой харьцуулахад үр дүн муутай болсныг харуулж байна.

Энэ нь олгосон зээл хөрөнгө бэлтгэхэд зориулж олгосон, зээлийг төсөлд тусгасан зориулалтаар ашиглаагүй, зарим иргэнд зээлийг нэмэгдүүлж олгосноос шалтгаалсан байна. Тухайлбал:

- 2016-2021 онд иргэнд 5-н иргэн, 1 аж ахуй нэгжид зоорь барих зориулалтаар 208.0 сая төгрөг
- 2019 онд “Далай энерги групп”-д “Материалын тооцоо, тээврийн зардал, гаалийн татвар” зориулалтаар 100.0 сая төгрөг /зориулалтын дагуу зарцуулаагүй/
- 2019 онд иргэн Д.Эрдэнэ-Очирын 30.0 сая төгрөгийн төсөлд 80.0 сая төгрөгийн зээл олгосон байна.

Үйлдвэржилтийг дэмжих зорилгоор олгох хөнгөлөлттэй зээл нь үр дүн муутай байгаа тул аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангийн мөнгөн хөрөнгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлэх нь зүйтэй байна.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ХЭҮЗ-ийн 2017 оны 02 дугаар тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, үүргийн зөвлөлийн дүрэм”-ийг баталсан байна. Зөвлөл нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн түншлэгч талын оролцоог хангах, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг удирдан зохицуулах зөвшилцлийн байгууллага байна гэж тодорхойлсон байна.

Дүрмийн 2 дахь хэсгийн 2.1.5-д “Тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн төсвийг бүрдүүлэх, хуваарилах асуудал хэлэлцэж зөвлөмж гаргах...,” гэж заасан байна. Гэтэл аймгийн зөвлөлөөс сангийн төсвийн төлөвлөлттэй холбоотой тодорхой ажил хийгдээгүй, дүгнэлт гараагүй байна.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн 2016-2021 оны тайлан болон хуралдааны тэмдэглэлээс үзэхэд 2016-2021 онд Хөдөлмөр эрхлэлтийн дэд сангийн төсвийг хуваарилах, 2018 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2019-2020 оны хөтөлбөрт санал өгөх, 2019, 2020 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээний хэрэгжилтийг сайтар хангуулах чиглэлээр сумдын Засаг дарга нарт зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилтийг тооцож, ХЭЗ хэлэлцээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна. **Үүнд:**

- Хөдөлмөр эрхлэлтийн газар болон Засаг даргын тамгын газар бусад нэгжүүдийн ажлыг уялдуулах,
- Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасан хөдөлмөр эрхлэлтийн байдал мөн аж ахуйн нэгж байгууллагаас төлөх төлбөрийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн санд төвлөрүүлэх,
- Орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, авсан арга хэмжээний, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, үр нөлөөнд жил бүр үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргах,
- Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон үр дүнгийн судалгааг тодорхой давтамжтайгаар мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудтай хамтран хийж эрэлттэй болон илүүдэлтэй мэргэжлийн талаарх мэдээллээр хангах,
- Хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх төрийн байгууллага аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, ХБТХОХ, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Хүнс хөдөө аж ахуйн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын газар болон бусад нэгжүүдийн үйл ажиллагааг уялдуулах ажлыг тус тус зохион байгуулж үр дүнг үнэлээгүй байна.

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс аймгийн хөдөлмөр эрхлэлтийн чиг үүрэг бүхий төрийн байгууллага болон нэгжийн үйл ажиллагаа харилцан уялдаагүй болсон байна.

Мөн аймгийн ХЭЗ нь дүрэмд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс гадна зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа болох хуралдаанаас гаргасан 2020 оны №1, 2021 оны №1 хурлын тэмдэглэлээс бусад хуралдааны тэмдэглэл нь хүчин төгөлдөр бус байна.

ХЭҮЗ-ийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хоёрдугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 3.6¹-д заасантай нийцэхгүй байна.

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулийн 28.7²-д зааснаар аймгийн зөвлөлд аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга, ажилтныг оруулахыг хориглосон заалттай боловч Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 2 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрмийн 3.8³-д зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хөдөлмөрийн хэлтсийн дарга байхаар зохицуулсан байгаа нь хууль тогтоомжийн холбогдох заалтууд хоорондоо зөрчилдөөнтэй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зарим бодлогын хэрэгжилтийг тайлагнаагүй, хууль журамд заасан хугацаанд ХШҮ хийгээгүй байна.

Аймгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд болон төрөөс хэрэгжүүлж байгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд хийсэн ажлын тайлан, ХШҮ хийсэн байдлыг хянаж үзэхэд дараах байдалтай байна.

Хөвсгөл аймагт хэрэгжсэн хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал.

Хүснэгт № 10

№	Хөдөлмөр эрхлэлт дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх	Тухайн байгууллагын үнэлгээ	ХШҮ хийсэн байдал	
			ХШҮ хийсэн эсэх	ХШҮ үнэлгээ
2016 он				
1	“Хөгжсөн Хөвсгөл” хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилт, арга хэмжээ	-	Үгүй	-
2	Аймгийн ЗДҮАХ “хөгжлийн хөтөч”	Хангалттай	Тийм	Тийм
3	2016 оны аймгийн “Үндсэн чиглэл”-д тусгагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилт, арга хэмжээ	Хангалттай	Үгүй	Үгүй
2017 он				
1	“Хөгжсөн Хөвсгөл” хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилт, арга хэмжээ	Хангалттай	Тийм	Тийм
2	Аймгийн ЗДҮАХ “хөгжлийн хөтөч”	Хангалттай	-	-
3	2017 оны аймгийн “Үндсэн чиглэл”-д тусгагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилт, арга хэмжээ	Хэрэгжих боломжтой	Үгүй	Үгүй
2018 он				
1	“Хөгжсөн Хөвсгөл” хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилт, арга хэмжээ	-	Үгүй	-
2	Аймгийн ЗДҮАХ “хөгжлийн хөтөч”	Хангалттай	Тийм	Тийм
3	2018 оны аймгийн “Үндсэн чиглэл”-д тусгагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилт, арга хэмжээ	Хангалттай	Үгүй	Үгүй
2019 он				
1	“Хөгжсөн Хөвсгөл” хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилт, арга хэмжээ	-	Үгүй	-
2	Аймгийн ЗДҮАХ “хөгжлийн хөтөч”	Хангалттай	Тийм	Тийм
3	2019 оны аймгийн “Үндсэн чиглэл”-д тусгагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилт, арга хэмжээ	Хангалттай	Үгүй	Үгүй
2020-2021 он				
1	“Хөгжсөн Хөвсгөл” хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилт, арга хэмжээ	-	Үгүй	-
2	Аймгийн ЗДҮАХ “хөгжлийн хөтөч”	Хангалттай	Тийм	Тийм
3	2020 оны аймгийн “Үндсэн чиглэл”-д тусгагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилт, арга хэмжээ	Хангалттай	Үгүй	Үгүй
4	“Жимс жимсгэнэ” дэд хөтөлбөр	62.5%	Тийм	52.6%
5	“Хүнсний ногоо” дэд хөтөлбөр	70%	Тийм	60%
6	“Жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх” дэд хөтөлбөр	-	Үгүй	-
7	“Хоршоо хөгжүүлэх” дэд хөтөлбөр	72.5%	Тийм	56.4%

¹ Зөвлөлийн хуралдаанаас гаргасан тэмдэглэл, санал дүгнэлт, зөвлөмж, тогтоолыг гишүүдэд танилцуулан, зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно”

² Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн гишүүнээр хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга, ажилтныг оруулахыг хориглоно.

³ ... Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтсийн дарга байна.

8	“Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх” дэд хөтөлбөр	-	Үгүй	-
Нийт үнэлгээ		Нийт 13 бодлогын баримт бичгээс 4-д нь буюу 30.7%-д ХШҮ хийгдсэн байна.		

Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй урт, дунд, богино хугацааны хөтөлбөрүүдийн хэрэгжилтээс харахад хөтөлбөрүүдийг заасан хугацаанд холбогдох байгууллагад тайлагнаж хэвшээгүй, ХШҮ хийлгээгүй байгаа нь тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтын хүрээнд 2016-2021 онд хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтийг тайлагнаж, тогтоосон хугацаанд ХШҮ хийлгээгүй байна.

БҮЛЭГ 2. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь тодорхой үр дүнд хүрсэн байна.

2.1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний тоон мэдээлэл бодитой бус, үр нөлөөг үнэлэх боломжгүй байна.

Аймгийн ХХҮГ нь ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах; нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах зэрэг Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлж байна.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг 2016-2021 онд нийт 13050 хүнийг хамруулахаар төлөвлөж 17887 иргэнийг хамруулсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 11 /сая.төг/

№	Иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд хамруулсан төлөвлөгөө, гүйцэтгэл	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
1	Төлөвлөгөө	34.0	11.6	18.2	30.4	20.4	16.8
2	Гүйцэтгэл	24.5	11.6	18.2	29.9	20.4	16.7
	Гүйцэтгэл хувь	72.1%	100 %	100 %	98.4 %	100 %	99.4 %
3	Зөвлөгөө мэдээлэлд хамруулах хүний тоо	2200	2000	2250	2300	2100	2200
4	Зөвлөгөө мэдээлэлд хамруулсан тоо	1924	1700	2800	6232 /Цахим/	2603	2628
	Хэрэгжилт хувь	87.4 %	85 %	124.4 %	270.9 %	123.9 %	119.4 %

Нийтлэг үйлчилгээ нь 2016, 2017 он нь хүрсэн түвшиндээ хүрээгүй боловч сүүлийн жилүүдэд төлөвлөсөн хэмжээнээс давсан үзүүлэлттэй байна. Гэхдээ 2019 оноос хойш цахимаар зөвлөгөө, мэдээлэл хүргэсэнтэй холбоотойгоор хамрагдсан хүний тоо өссөн гэж холбогдох албан тушаалтан мэдээлж байгаа боловч цахимаар үнэн бодитой байдал эргэлзээтэй байна.

Тухайлбал: Ямар цахим систем ашиглаж зөвлөгөө мэдээлэл хүргэсэн тайлан мэдээ, хамрагдсан иргэний бүртгэл байхгүй.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институтээс 2017, 2018 онд хийсэн Хөдөлмөрийн зах зээлийн Барометрийн судалгааг Хөвсгөл аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааны үзүүлэлттэй харьцуулахад:

№	Ажиллах хүчний эрэлттэй салбар /Улсын хэмжээнд/	Мэргэжил сонголтын Судалгаа /Хөвсгөл/	Сонгон суралцсан Байдал /Хөвсгөл/
1	Боловсруулах үйлдвэрлэл	Анагаах ухаан	Эрх зүй
2	Барилга	Цэрэг, Цагдаа	Анагаах ухаан
3	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Хууль эрх зүй	Нягтлан бодох бүртгэл

Сурагчдын мэргэжил сонголтод хийсэн судалгааны дүн, оюутны сонгон суралцаж буй мэргэжлээс харахад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ үр дүнтэй хэрэгжээгүй гэж аудитаар үзлээ.

Ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлан ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээлэл өгөх нийтлэг үйлчилгээг хүргэх нь зүйтэй байна.

Ашиглаж буй (LMIS) системийг ил тод нээлттэй, тоон мэдээллийг ялган боловсруулах боломжтой байдлаар сайжруулалт хийх шаардлагатай байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ болох ажилд зуучлах болон зөвлөгөө мэдээлэл өгсөн судалгааг нэгтгэх LMIS системийг ашиглан мэдээллийн санг бий болгон ажиллаж байна.

Дээрх мэдээллийн санд 2016-2021 онуудад нийт 7450 иргэнийг ажилд зуучлахаар төлөвлөж 7091 иргэнийг ажилд зуучилсан байна. Аймгийн хэмжээнд жилд дунджаар 1181 иргэнийг ажилд зуучилсан бөгөөд нэг суманд 49 иргэнийг ажилд зуучилсан тоон мэдээллийг ХХҮГ-ын LMIS программаас гаргасан байна.

Тус системд идэвхтэй ажил хайгч, зөвлөгөө мэдээлэлд хамрагдсан иргэд, ажилд зуучлуулсан иргэд, ажиллаж байгаа иргэд, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэд, ажил олгогчийн бүртгэл, ажлын байрны захиалга зэрэг мэдээллийг тус системд оруулдаг байна.

Тус системд дээрх мэдээллүүд байгаа хэдий ч олон нийтэд ил тод нээлттэй бус ажил олгогч ажил хайгч нарын мэдээлэлтэй танилцах боломжгүй хаалттай систем тул ашиглалт нь зөвхөн ХХҮГ болон сумын хөдөлмөрийн хариуцсан мэргэжилтэн, ХХҮЕГ-ын холбогдох албан тушаалтнуудын хүрээнд ашиглаж байна.

Тус программын тоон мэдээллийг ХХҮЕГ-ын даргатай ХХҮГ-ын даргын байгуулсан 2019 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг түүвэрлэн тулгалт хийж үзэхэд 2019 онд 1250 хүнийг ажилд зуучлахаар төлөвлөж 1400 хүнийг ажилд зуучилснаар буюу 150 хүний мэдээллээр зөрүүтэй байна. Графикаар харуулбал:

График № 1



ХХҮЕГ-ын даргатай аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын даргын байгуулсан үр дүнгийн гэрээнд ажилд зуучлах иргэнийг тоог төлөвлөдөг байна.

Тухайлбал: 2019 оны үр дүнгийн гэрээний 3.3-т “... ажлын байранд захиалга авч, ажилгүй иргэдийг ажлын байранд зуучилсан байна” заалтын зорилтод түвшин нь 1543 иргэнийг түр болон ажлын байранд зуучлах бөгөөд дээрх заалтыг хэрэгжүүлэхийн тулд LMIS системд бүртгэгдээгүй ажил эрхэлж буй иргэнийг бүртгэх нөхцөл үүсэж байна. Энэ нь мэдээллийн системийн тоон мэдээллийг бодитой бус байхад нөлөөлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг ХХҮЕГ-тай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг тайлагнасан хэдий ч зарцуулсан хөрөнгийн үр ашгийг тооцож тайлагнаагүй байна.

2016-2021 онуудад байнгын ажлын байранд зуучлуулсан иргэд тогтвортой ажиллаж байгаа эсэхийг Хөдөлмөрийн хэлтсийн ЭЛЭМИЭС (LMIS) программаар тулгалт хийхэд уг программд улсын хэмжээнд Хөвсгөл аймгийн харьяалалтай хүн ажлын байртай болсныг нэгтгэн бүртгэдэг тул зөвхөн тухайн орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсээр зуучлуулсан ажлын байрыг тусгаарлаж үзэх боломжгүй байна.

Мөн тус программд аймгийн ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг авсан иргэд, үйлдвэр дээрх сургалтад хамрагдсан иргэдийн нэрсийг байнгын ажлын байртай болсноор бүртгэсэн нь аймгийн ХХҮГ-ын хөдөлмөрийн хэлтсийн зуучлалаар нийт хэдэн иргэн байнгын ажлын байртай болсныг тодорхойлох боломжгүй байлаа.

Иймд ашиглаж буй тус системийг ил тод нээлттэй, тоон мэдээллийг ялган боловсруулах боломжтой байдлаар сайжруулалт хийх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Өөрөөр хэлбэл зөвхөн аймгийн ХХҮГ-ын хөдөлмөрийн хэлтсийн зуучлалаар бий болсон ажлын байрны мэдээлэл, бий болсон ажлын байранд байнгын тогтвортой ажиллаж байгаа эсэх мэдээллийг аймгийн НДХ-тэй уялдуулж тайлагнадаг байх шаардлагатай байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хэрэгжилтийг ХХҮЕГ-тай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг тайлагнасан хэдий ч зарцуулсан хөрөнгийн үр ашгийг тооцож тайлагнаагүй байна.

2.2. Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангаас хөнгөлөлттэй зээлд хамрагдаж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд нь байнгын болон түр ажлын байрыг бий болгох, үйлдвэржилтийг дэмжих гэсэн үндсэн зорилтуудыг хангаагүй, үр дүн тооцоогүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр ХЭДС, СХС, ЖДҮХС, ЖДҮХОНТС /аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан, Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан/-ийн хөрөнгөөр хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж, хөнгөлөлттэй зээлийг олгосон байна.

ХЭДС-ийн хөрөнгийг ХЭҮЗ-өөс баталсан журам, удирдамжийн дагуу зарцуулж ажлын байрыг урьдчилан төлөвлөдөг бол бусад сангуудын тухайд тухайлан заасан журам⁴д заасан шалгуурыг хангасан иргэн, аж ахуй нэгжид хөнгөлөлттэй зээл олгох байдлаар сангийн хөрөнгийг зарцуулдаг бөгөөд ажлын байрыг урьдчилан төлөвлөдөггүй байна.

Дээрх сангуудаас 2016-2021 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх үндсэн зорилтын хүрээнд нийт 19,568.8 сая төгрөгийг зарцуулж байнгын ажлын байр 2807, түр ажлын байр 4943-н ажлын байр хадгалагдсан байна. Хүснэгт № 12

№	Сангийн нэр	Зарцуулсан хөрөнгө /дүн сая.төг/	Хэрэгжүүлсэн хөтөлбөр, олгосон зээлийн тоо		Зээлийн хүү /жилийн/	Бий болсон ажлын байр	
			Хөтөлбөрийн тоо	Зээлийн тоо		Байнга	Түр
1	ХЭДС	9,013.1	5	1858	0	1921	4443
2	СХС	6,841.8	-	1056	3	537	346
3	ЖДҮХС	1,348.7	-	28	3	56	95
4	Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан	1,248.1	-	32	7	48	49
5	Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан	1,117.1	-	245	7	245	59
Нийт		19,568.8	-	1361		2807	4943

Дээрх сангуудаас ХЭДС, СХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн хөтөлбөр болон хөнгөлөлттэй зээлд хамрагдсаны үр дүнд ажлын байр нэмэгдсэн тоон үзүүлэлт байгаа хэдий ч аудитаар талбар дээр очиж үзэхэд зарим төсөл, арга хэмжээ нь ажлын байр нэмэгдүүлээгүй, үйл ажиллагаа зогссон тодорхой үр дүнд хүрээгүй тохиолдлууд байна.

Жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх сангийн тухайд:

Монгол Улсын засгийн газрын 2020 оны 113 угаар тогтоолоор Экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, инновацийг дэмжих, шинээр бизнес эхлүүлэх болон ажлын байр бий болгох, нэмэгдүүлэх зорилгоор Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар Хөвсгөл аймагт 2019-2020 онд тус бүр нэг тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн багцыг баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/218 дугаар захирамжаар 8 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулсан ЖДҮХС-с төсөл сонгон шалгаруулсан байна.

Аймгийн хэмжээнд 2019-2020 онд нийт 102 төсөл хүлээн авч 28 төслийг сонгон шалгаруулж, 1,348.7 сая төгрөгийн зээл олгосон байна.

Аймгийн хэмжээнд 2019 онд 61 төсөл хүлээн авч 21 иргэн, аж ахуйн нэгжид 871.4 сая төгрөгийн, 2020 онд 41 төсөл хүлээн авч 7 аж ахуйн нэгжид 477.3 сая төгрөгийн дүнтэй зээлийг тус тус олгосон байна.

Хөнгөлөлттэй зээлийг Хүнс, Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар зээл олгох 9 салбарыг тодорхойлсон байна. Үүнд:

- Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах
- Дотор мах, дайвар бүтээгдэхүүн боловсруулах
- Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ боловсруулах
- Зоорь хүлэмжийн аж ахуй

⁴ ЖДҮХОНТС-аас зээлийг олгохдоо аймгийн ИТХ-аас 2016 оны 20 дугаар тогтоолоор баталсан журмыг баримтлан арилжааны банкаар дамжуулан зээл олгодог.

- Арьс, шир боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэх
- Сав баглаа боодол үйлдвэрлэх
- Аялал жуулчлалын үйлчилгээ
- Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, ариутгал халдваргүйжүүлэлтийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх

Төслийн зээлийн үр дүнд 28 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа хэвийн явуулж 53 ажлын байр хадгалагдаж байна.

Аймгийн Хүнс,Хөдөө аж ахуйн газар нь зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн олгосон зээлийн үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн талаарх тайланг зээлдэгчээс улирал бүр гаргуулан аваагүй байна. Тус сангаас 2019-2020 онд олгосон зээлийн 20-н төсөл арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрлэн үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №13

№	Он	Төслийн тоо	Олгосон зээл /сая төг/	Үр дүн	Тайлбар
1	2019	13 /түүвэр/	640.0	617.0 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээ зориулалтын дагуу зарцуулсан байна.	23-н сая төгрөгийн /арьс шир/ 1 төсөл хэрэгжээгүй байна.
2	2020	7	495.1	445.1 сая төгрөгийн 6-н төсөл арга хэмжээ зориулалтын дагуу зарцуулсан байна.	50 сая төгрөгийн /хүлэмж, зоорь барих/ 1 төсөл хэрэгжээгүй байна.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээлийн дийлэнх нь үр дүнд хүрсэн хэдий ч зарим иргэн аж ахуй нэгж цар тахлын нөлөөнөөс шалтгаалан үр өгөөжөө хүртээгүй байна. Хэрэгжээгүй 2 төслийн шалтгааныг тодруулахад цар тахлын улмаас төсөлд тусгасан үр дүнд хүрч чадаагүй байна.

Үнэлгээ өгсөн байдал: Хөнгөлөлттэй зээлийн хэрэгжилтийн явцыг 2020 оны 8 дугаар сард ХХААЯ-ны жижиг дунд үйлдвэрийн газраас ажлын хэсэг ирж хяналт хэрэгжүүлсэн байна. /ямар нэгэн үнэлгээ өгөөгүй байна./

Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангийн тухайд: Үйлдвэржилтийг дэмжих сангийн хөрөнгийг 2017 оны 12 сарын 07-ний өдөр ХААН банктэй “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сангийн зээл олгох талаар хамтран ажиллах гэрээ” байгуулж, гэрээнд зааснаар зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээг 100.0 сая төгрөг, зээлийн хүүг жилийн 10%-иас хэтрүүлэхгүй, зээлийн хугацаа 36 сар байхаар тогтоон мөрдөж байна.

Тус сангаас 2016-2021 онд 9 аж ахуй нэгж 463.0 сая, 23 иргэнд 785.1 сая төгрөг, нийт 1,248.1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна.

Аудитаар тус сангийн үйл ажиллагаанд хяналт хийхэд дараах зөрчил илэрч байна. **Үүнд:**

- эрэмбэлсэн төсөлд зээл олгоогүй,
 - төсөл ирүүлээгүй аж ахуй нэгжид зээл олгосон,
 - зээлийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж олгосон,
 - зээл олгохоор шийдвэрлэсэн хурлын тэмдэглэлийг бүрэн баталгаажуулаагүй
 - төсөл сонгон шалгаруулах комисс чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй
 - комиссын үйл ажиллагаанд хяналт байхгүй байна. **Тухайлбал:**
1. Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт бүртгэлтэй “Далай энерги групп”-т материалын тооцоо, тээврийн зардал, гаалийн татвар төлөх зориулалтаар 100.0 сая төгрөгийн зээлийг 2019.12.31-ний өдөр олгосон байна.
 2. “Ончин жалба” уламжлалт мэдрэлийн эмнэлэг байгуулахаар иргэн Д.Эрдэнэ-Очироос ирүүлсэн 30.0 сая төгрөгийн төсөлд 80.0 сая төгрөгийн зээл олгосон байна. /Төсөл сонгон шалгаруулах комиссоос гаргасан шийдвэрийг арилжааны банк нэмэгдүүлж олгосон/
 3. Төсөл ирүүлээгүй 10 иргэн, аж ахуй нэгжид 411.0 сая төгрөгийн зээлийг олгосон байна.

Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангаас хөнгөлөлттэй зээлд хамрагдаж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд нь байнгын болон түр ажлын байрыг бий болгох, үйлдвэржилтийг дэмжих гэсэн үндсэн зорилтуудыг хангаагүй, тодорхой үр дүн гаргаагүй байна.

Иймд дээрх үйлдвэржилтийг дэмжих сангийн үйл ажиллагааг цаашид хэрэгжүүлэх шаардлага байхгүй байна.

Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сангийн тухайд:

“Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-ийн хөрөнгийг 2016 оны 07 сарын 04-ний өдөр ХААН банкт “Аймаг орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар хамтран ажиллах” гэрээ байгуулж, гэрээний 2.4.1-2.4.3-д нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээг 10.0 сая төгрөг, зээлийн хүүг жилийн 7%, зээлийн хугацаа 24 сар байхаар тогтоосон байна.

“Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-аас олгосон зээл олголтын мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 14 /сая.төг/

Он	Төсөлд хамрагдсан өрхийн тоо	Олгосон зээлийн эхний үлдэгдэл	Тухайн онд олгосон зээлийн дүн	Эргэн төлөлт	Олгосон зээлийн эцсийн үлдэгдэл 2021.12.31-өдрөөр	Шинээр ажлын байр	
						Байнга	Түр
2016	51	240.9	179.2	223.1	284.8	51	
2017	76	284.8	357.8	225.6	152.6	76	25
2018	34	152.6	188.0	210.3	274.9	34	15
2019	46	174.9	184.7	132.2	122.4	46	10
2020	26	122.4	116.7	88.6	94.3	26	9
2021	12	94.3	90.7	91	94.6	12	
Нийт	245	1,069.9	1,117.1	970.8	1,023.6	245	59

/Мэдээллийн эх сурвалжийг ХААН банкны Зээлийн төвөөс авав./

Хүснэгтээс харахад: Аймгийн хэмжээнд 2017-2021 онуудад зээл олголт буурсан үзүүлэлттэй байгаа нь дараах үндсэн шалтгаантай байна. Үүнд:

- орон нутгийн төрийн байгууллага иргэдэд мэдээллийг ил тод тэгш хүртээмжтэй хүргээгүй байна. – **Цагаан-үүр, Чандмань-өндөр, Түнэл, Мөрөн, Жаргалант сумдад аудитын хугацаанд ажиллахад сумын Засаг дарга, холбогдох мэргэжилтнүүд тус сангийн талаар ямар ч мэдээлэлгүй, ямар иргэн тус зээлд хамрагдаж төсөл хэрэгжүүлж байгаа талаар мэдээлэл хомс байна.**
- тус сангийн эх үүсвэр нь аилжааны банкинд байршиж байгаа тул банкны зээлийн шалгуур үзүүлэлтийг хангахгүй байгаагаас зээлд хамрагдаж чадаагүй – **Аудитаар ажилласан сумдын хариуцсан мэргэжилтнүүдтэй уулзахад арилжааны банкинд байршиж, тус банкны зээлийн шалгуурыг хангах шаардлага тавигддаг тул барьцаа хөрөнгөгүй, орлого тодорхойлох боломжгүй иргэнд хамрагдаж чадахгүй байгаа талаар ярьж байна.**
- сангийн хөрөнгийг иргэдэд тэгш хүртээмжтэй, шударга олгогдох боломжийг хязгаарлаж байна - **“Төсөл сонгон шалгаруулах хороо”-оор хэлэлцэхгүйгээр шууд Засаг даргын тоотойр дэмжиж арилжааны банканд хүргүүлж байна.**

“Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-ийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэний үйл ажиллагаанд 2020 оны 6 дугаар сард аймгийн хэмжээнд нэгдсэн байдлаар хяналтыг хэрэгжүүлсэн боловч үр дүнг бодитой тооцож чадаагүй байна.

“Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-ийн эх үүсвэрээр хөнгөлөлттэй зээлд хамрагдаж байгаа иргэдийн талаарх нэгдсэн судалгаа аймгийн хэмжээнд байхгүй, бусад хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллагаагүй, ажлын хэсэг байгуулж хяналт хэрэгжүүлэх шийдвэр гаргасан боловч үр дүнг тооцоогүй зэргээс харахад сумдын удирдлага, холбогдох албан тушаалтан, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн үйл ажиллагаа хангалтгүй байгааг харуулж байна.

Сум хөгжүүлэх сангийн тухайд: Сум хөгжүүлэх сангаас 2016-2021 онд 1068 иргэн, ААН-д 7,087.3 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Хүснэгт №15

Он	Зээлд хамрагдсан хүний тоо	Нийт олгосон зээл
2016	99	508.6
2017	140	901.5
2018	249	1,668.0
2019	254	1,422.4
2020	193	1,459.7
2021	133	1,127.1
Нийт	1068	7,087.3

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хүрээнд бодитоор бий болсон ажлын байрыг бүртгэх бүртгэл мэдээллийн сан байхгүй байна. Сумын ИТХ, ИТХ-ын зээлийн хяналтын хорооноос Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хэрэгжилт, зарцуулалтад хяналт тавьж ажилладаг ч хяналтын үр дүн гараагүй байна. Тухайлбал: Аудитаар мөрөн сумын зээлийн хэрэгжилтэд түүвэр хяналт хийхэд Мөрөн суманд 5 иргэн зээлийг зориулалт бусаар ашиглаж буй тохиолдол илэрч байна.

Мөн сум хөгжүүлэх сангаас олгосон журамд зээлийг зориулалт бусаар ашигласан тохиолдолд зээлийг эргүүлэн татаж, ахин зээл олгохгүй байх гэснээс өөрөөр алданги, торгууль зэрэг тооцох

заалт байдаггүй нь зээлийн үр дүнг бууруулах, зориулалт бусаар ашиглахад нөлөөлж болохуйц байна.

Олгосон зээлийн эргэн төлөлтөд анхаарч ажиллаж байгаа хэдий ч зээлийг зориулалтын дагуу ашиглуулахад тавих хяналт сул, журмын зохицуулалт муу мөн зээл авахад төсөлд тусгагдсан байнгын ажлын байрыг үүсгэж ажиллаж байгаа эсэхэд хяналт тавихгүй, энэ нь мөн хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн нэгдсэн санд бүрэн бүртгэгдэхгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн тогтвортой хэрэгжиж байгаа төслүүдийг зургаар харуулбал:

Их-Уул сумын иргэн Н.Энхтуяа: 2021 онд “Талх үйлдвэрлэл”-ийн зориулалтаар 5.0 сая төгрөгийн зээлийг СХС-аас авч үйлдвэрлэлийн 3х2 хэмжээтэй барилгыг 8х6 болгон өргөтгөж үйлдвэрлэлийн хүчин чадал нэмж шинээр 2 ажилтан авч ажиллуулж байна.



Тосонцэнгэл сумын иргэн Д.Нансалмаа: 2021 онд “Оёдол эсгүүр”-ийн зориулалтаар 4.0 сая төгрөгийн зээлийг СХА-аас авч ажлын байр барин, шинээр 1 ажилтан авч ажиллуулж байна.



2016-2021 онуудад ХЭДС, СХС-ийн хөрөнгөөр төсөл хэрэгжүүлэхээр 5.0-10.0 сая төгрөгийн зээл авсан иргэдийн хэрэгжүүлсэн төслүүдээс үйл ажиллагаа тогтвортой, ажлын байр хадгалсан, ажлын байр нэмэгдүүлсэн эерэг үзүүлэлттэй байхад 800.0 гаруй сая төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмж бүхий хуурай сүүний үйлдвэр 2017 оноос хойш одоог хүртэл ажиллаагүй байна.

Үүнд: Засгийн газрын 2016 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Мах, сүүний анхдугаар аян” хөтөлбөрийн хүрээнд Хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр “Монгол Драй Милк” ХХК-иас 2017 онд Их-Уул сум, Галт суманд нийлүүлсэн тус бүрийн үнэ нь 800.0 гаруй сая төгрөг буюу нийт 2,000.0 орчим сая төгрөгийн үнэтэй хуурай сүүний үйлдвэрийн тоног төхөөрөмжийг одоог хүртэл ашгаа өгөөгүй байна.

Зургаар харуулбал.



Нээлт хийсэн үеийн зураг /Их-Уул сум 2017.06.24/



Хуурай сүүний үйлдвэр одоогийн зураг /Их-Уул сум 2022.04.05/

Энэ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн төрийн бодлого харилцан адилгүй үр дүнтэй хэрэгжиж байгааг харуулж байна.

ХЭДС, СХС, ЖДҮХС, -ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнасан байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар **ХЭДС, ЖДҮХС**-ууд, Төсвийн тухай хуулиар **ҮДС, ӨҮДС, СХС, /ОНТС/-уудын** төлөвлөлт гүйцэтгэл, тайлагналыг зохицуулж байна. Мөн тус бүрдээ Засгийн газраас гаргасан журмаар нарийвчлан зохицуулж байна.

ХЭДС, ЖДҮХС нь дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд, бусад орон нутгийн тусгай сангууд нь аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэгт орж тайлагнагдаж байна.

Сангуудын санхүүгийн тайлан туссан байдлыг хүснэгтээр харуулбал. *Хүснэгт № 16/сая төг/*

Сангууд	Санхүүгийн тайлангийн орлого, зарцуулалт	2016-2021 он			Тайлбар
		Дүн			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	
ХЭДС	Орлого	9,700.0	11,085.6	1,385.6	
	Зарцуулалт	9,182.7	11,074.6	1,891.9	
ЖДҮХС	-	1,500.0	1,348.7	(151.3)	Зээлийн эх үүсвэр дутуу ирсэн
ҮДС	-	-	1,248.1	1,248.1	ҮДС-ийн зээлийн эх үүсвэрээс олгосон зээл
ӨҮДС	-	-	1,068.1	1,068.1	ӨҮДС-ийн зээлийн эх үүсвэрээс олгосон зээл
СХС	-	13,241.3	9,479.7	9,479.7	СХС-ийн зээлийн эх үүсвэрээс олгосон зээл
ДҮН	-	34,692.1	24,577.0	3,126.2	

Эх сурвалжийг санхүүгийн тайлангаас авав.

ХЭДС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнасан байна.

Сум хөгжүүлэх сангаас 2016-2021 онуудад аймгийн хэмжээнд 23 сумын 1419 иргэнд 9,479.7 сая төгрөгийн зээл олгож, нийт зээл, хүүгийн авлага 10,196.2 сая төгрөгөөс эргэн төлөлтөөр 6,120.7 сая төгрөг төлөгдөж, 2021 оны жилийн эцсээр 4,075.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн 2016-2021 онуудын эргэн төлөлтийг эргэн төлөлтийг задалж харуулбал: - Зээлийн үндсэн төлбөрт 5,683.6 сая төгрөгийн үндсэн зээл, 437.0 сая төгрөгийн хүү, алданги төлөгдсөн байна.

Аймгийн үйлдвэрлэлийг дэмжих сан, Өрх гэрийн үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэн тайлагнаж байна.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар тусгайлан арга хэмжээ аваагүй ч СХС, ХЭДС-аас олгож буй зээл, санхүүгийн дэмжлэгийн 40 орчим хувьд эмэгтэйчүүд хамрагджээ.

Аймгийн ХХҮГ-т ажил хайгч иргэнээр 2016-2021 онд нийт 6275 иргэн бүртгүүлснээс 3130 нь эмэгтэйчүүд байна. Хүснэгтээр харуулбал:


Хүснэгт № 17

№	2016	2017	2018	2019	2020	2021
Ажил хайгч иргэн	1232	909	1483	1367	827	457
Үүнээс: Эмэгтэй	642	452	717	704	419	196
Эзлэх хувь	52%	50%	48%	51%	51%	43%

Тоон үзүүлэлтээс харахад ажил идэвхтэй хайгч иргэдийн 50 орчим хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих зорилт, арга хэмжээ тусгагдсан хэдий ч 2018 онд Эмэгтэйчүүдийн чуулганыг зохион байгуулснаас өөр арга хэмжээг зохион байгуулаагүй байна.

Харин эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн бодлого хэрэгжээгүй ч хувиараа хөдөлмөр эрхлэхээр СХС, ХЭДС-аас нийт 808-н эмэгтэй 3,906.8 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан байна. ХЭДС, СХС-ийн зээлд хамрагдалтыг графикаар харуулбал: График № 2



СХС, ХЭДС-аас олгох зээлийн 40 хувьд эмэгтэйчүүд хамрагдсан байгаагаас харахад эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал идэвхтэй байгааг харуулж байна.

2016-2021 онд Засгийн газраас эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар тусгайлсан бодлого арга хэмжээг хэрэгжүүлээгүй байгаа ч 2022 онд Хөдөлмөр эрхлэлтийг

дэмжих сангаас Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-ийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төлөвлөөгүй байна.

Аймгийн ХЭДС-д орон нутгийн төсвөөс 2016-2021 онд нийт 1,680.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэх боломжийг алдсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлд зааснаар Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан /дэд сан/ дараах эх үүсвэрээс бүрдэхээр байна.

- Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө
- Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө
- Гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл
- Гадаад улс, олон улсын байгууллага, Монгол улсын болон гадаад улсын ААНБ, ТББ, иргэдээс ХЭДС-д оруулсан хандив тусламж
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй ААНБ-аас төлөх төлбөр

Аймгийн ХЭДС-ийн 2016-2021 оны эх үүсвэрийг графикаар харуулбал:

График № 3 /сая төгрөгөөр/



Графикаас харахад 2016-2021 онуудад орон нутгийн төсвөөс орлого төвлөрөөгүй байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1 –д заасны дагуу 25 болон түүнээс дээш ажиллагсадтай ААНБ-аас төлөх ХБИ-ийг ажиллуулаагүй төлбөрийг 2016-2018 онд огт төлөвлөж, бүрдүүлээгүй, 2019-2021 онуудад орлогыг бүрэн бүрдүүлээгүй байна.

ХЭДС-д 2019-2021 онуудад Хаан банк, “Хөвсгөл Эрчим хүч” ХХК, “Хөвсгөл дулааны станц” ХХК зэрэг байгууллагуудаас нийт 10.5 сая төгрөгийн ХБИ ажиллуулаагүй төлбөрийг төлсөн байна.

ЗГ-ын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 2.2⁵-д заасны дагуу орон нутгийн төсвөөс аймгийн ХЭДС-д хуваарилах хөрөнгийг тооцож үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт № 18

Аймгийн төсвийн орлого	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
	84,021.6	81,206.4	90,587.0	89,684.1	111,021.8	103,491.1
ХЭДС-д аймгийн орлогоос хуваарилах дүн /0.3%/	252.1	243.6	271.8	269.1	333.1	310.5
Төлөвлөлт	0	0	0	0	0	0
Гүйцэтгэл	0	0	0	0	0	0

Аймгийн ХЭДС-д 2016-2021 онд нийт 1,680.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх боломжтой байсан байна. Энэ нь ХХҮГ-аас аймгийн орон нутгийн төсвийн төсөлд ХЭДС-д хөрөнгө тусгуулах санал хүргүүлээгүй, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс энэ талаар арга хэмжээ авч ажиллаагүйтэй холбоотой байна.

Орон нутгийн орлогоос ХЭДС-д хөрөнгө хуваарилаагүй нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2, Засгийн газрын 2011 оны 371 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 2.2 дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй төлбөрийг бүрэн төлөвлөж, бүрдүүлж ажиллаагүй нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.7, Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1, 111.2 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд ХЭДС-д орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилах төсвийн төслийг жил бүр аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлж ажиллах, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг бүрэн төвлөрүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

ХЭДС-ийн хөрөнгийг хууль журмын дагуу зарцуулсан боловч үр нөлөөг бүрэн тооцоогүй байна.

ХЭДС-ийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эргэх төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг, сургалт сурталчилгаа, туршлага солилцох арга хэмжээ, ажилд зуучлах болон хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн системтэй холбоотой үйл ажиллагаануудад зарцуулсан байна.

ХЭДС-аас 2016-2021 онд нийт 1858 иргэнд 4,833.5 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг олгосон байна.

Хүснэгт № 19


⁵ Дэд санд аймаг, нийслэл, дүүргийн төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь тухайн төсвийн орлогын 0,3 хувьас доошгүй байна.

№	Он	2016	2017	2018	2019	2020	2021	Нийт
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	-	36.0	70.0	70.0	45.0	52.0	273.0
2	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	220.5	297.0	344.0	320.0	278.0	113.0	1,572.5
3	Ахмад мэргэжилтнийг дэмжих хөтөлбөр	-	12.5	18.0	39.0	30.0	33.0	132.5
4	Залуучуудыг дэмжих хөтөлбөр	-	40.0	105.0	230.0	-	-	375.0
5	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	-	270.0	196.5	380.0	339.0	210.0	1,395.5
6	Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл	-	-	1,000.0	85.0	-	-	1,085.0
	Нийт олгосон санхүү дэмжлэг	220.5	655.5	1,733.5	1,124.0	692.0	408.0	4,833.5
	Нийт хамрагдсан хүний тоо	438	271	338	300	378	133	1,858.0

ХЭДС-аас малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт нийт санхүүжилтийн дийлэхийг буюу 61.4 %-ийг зарцуулсан байна.

Түүвэрт хамруулан аудит хийсэн суманд ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн зарим төсөл арга хэмжээний үйл ажиллагаа хэвийн бус байдалтай байхад малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдийн малын тоо толгой өссөн үзүүлэлттэй байна.

График: № 4



Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслөөр 2018 онд 1 тэрбум төгрөгийн зээлийг олгохдоо аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөр хэлэлцүүлээгүй олгосон байна. Аймгийн Засаг даргаас Авлигатай тэмцэх газарт хүсэлт хүргүүлсний хүрээнд шалгагдаж 6 иргэний 425.0 сая төгрөгийн дэмжлэгийг эргүүлэн татсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон санхүүгийн дэмжлэгээс 2021 оны 12 сарын 31-ний байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг хөтөлбөрөөр харуулбал:

Хүснэгт № 20

Хөтөлбөрийн нэр	2016	2017	2018	Нийт
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр		25.3		25.3
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	28.1	72.1	142.8	243.0
Ахмад мэргэжилтнийг дэмжих хөтөлбөр		3.5	5.3	8.8
Залуучуудыг дэмжих хөтөлбөр		9.3	68.7	78.0
Ажлын байрыг дэмжих хөтөлбөр		99.0	92.7	191.7
Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл			193.6	193.6
Хүний тоо	18.0	113.0	129.0	260
Хугацаа хэтэрсэн санхүү дэмжлэг	28.1	209.2	503.1	740.4

ХЭДС-аас 2016-2018 онд 2,609.5 сая төгрөгийн санхүү дэмжлэгийг олгосон байгаагаас 740.4 сая төгрөг буюу 29%-нь хугацаа хэтэрч эргэн төлөлт хийгдээгүй, 71 хувь хугацаандаа эргэн төлөлтөө хийж байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн зөрчлийг арилгахаар ХХҮГ нь 2020 онд ажлын хэсэг байгуулж шүүхэд шилжүүлэх, 2021 онд сумдад албан даалгаврыг хүргүүлж эргэн төлөлтийг эрчимжүүлэх ажлыг тус тус зохион байгуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр бүрд хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж өгдөг байна.

Харин төсөл хөтөлбөрийн үр дүнг аудитаар тооцож үзэхэд дараах зөрчилтэй асуудал байна. Үүнд:

- Аймаг, сумдын холбогдох төрийн байгууллага, албан хаагчдаас тус хөтөлбөрүүдийн үр дүнг тооцоогүй.
- Төсөл хөтөлбөрт хамрагдаж байгаа иргэн аж ахуйн нэгжийн хүсэн дүнгээр санхүүгийн дэмжлэг олгоогүй, санхүүгийн дэмжлэг бууруулсан шалтгаан тодорхойгүй, төсөл сонгон шалгаруулах ажлын комиссын үйл ажиллагаа хангалтгүй. Тухайлбал: Мөрөн суманд Хүснэгт №21

Он	Хүссэн дэмжлэгийн дүн	Олгосон дэмжлэг	Зөрүү
2017	361.5	298.2	63.3
2018	1,102.0	1,050.5	51.5
2019	621.0	508.4	112.6
2020	477.0	366.0	111.0
2021	257.0	228.0	29.0
Нийт	2,818.5	2,451.1	367.4

- Зээлийн эргэн төлөлтийг хугацаандаа төлж байгаа ч зориулалт бусаар ашигласан.
- Санхүүгийн дэмжлэгийг авсан боловч өндөр хүүтэй бусад зээлээ хаасан эсвэл өрхийн хэрэгцээнд зарцуулсан.

Аймгийн ХХҮГ-ийн Захиргаа хяналтын хэлтсээс хяналтыг тогтмол хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд хяналтын үр дүнгээр хэлтсийн ажилчдад зөвлөмж, албан шаардлагыг хүргүүлж хэрэгжилтийг тооцож ажилладаг байна. Захиргаа хяналтын хэлтэс нь 2016-2020 онуудад 3-5 зорилтын хүрээнд бүх сумд болон сургалт, нийтийг хамарсан арга хэмжээнд жилд дунджаар 30 орчим хяналтыг хэрэгжүүлж ажилласан, 2021 онд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой 152.1 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж холбогдох зөвлөмж, албан шаардлагыг хүргүүлж ажиллажээ.

Хяналт шинжилгээ үнэлгээний тайлангаас харахад программд эргэн төлөлтийн мэдээлэл зөрүүтэй оруулсан тохиолдлууд байсан бөгөөд хяналтаар илрүүлсэн зөрчлүүдийг тухай бүр программд залруулсан байна. Тухайлбал:

Хүснэгт № 22

№	Сумын нэр	Программын мэдээлэл зөрсөн	
		Хүний тоо	Мөнгөн дүн /төгрөгөөр/
1	Жаргалан сум	1	300 000
2	Цагаан-Уул сум	2	250 000
3	Цэцэрлэг сум	2	850 000

Энэ нь иргэдийн мэдээлэл зөрж программд зөрүүтэй бүртгэгдэх эрсдэлтэй байна.

Иймд цаашид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүү дэмжлэг олгосон болон эргэн төлөлтийн мэдээллийг программд тухай бүр оруулж мэдээллийг шинэчлэх, программын мэдээлэлтэй нэг бүрчлэн тулгаж хяналтыг

хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүддээ хяналт шинжилгээ хийсэн боловч үр нөлөөг тооцоогүй байна.

2.4. Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаа үр нөлөөтэй хэрэгжсэн байна.

Хөвсгөл аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 2021 оны 12 дугаар сарын 17-нд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны сайдын тушаалаар Хөвсгөл аймаг дахь Политехникийн коллеж болж үйл ажиллагаагаа өргөжүүлэн мэргэжлийн боловсролын сургалтыг олгож байна.

Политехникийн коллеж нь 1 болон 2,5 жилийн ангидаа 15-20 чиглэлээр элсэлт авч байна. Элсэлтийн квотын саналаа аймгийн орон нутгийн зөвлөлөөр хэлэлцүүлэн Удирдах зөвлөлөөр батлуулж Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлж батлуулдаг байна. Хөвсгөл аймаг

нь 2017 оноос аялал жуулчлалын тулгуур төв болох бодлогыг баримталж эхэлсэнтэй уялдуулан аялал жуулчлалын үйлчилгээний ажилтан, аялал жуулчлалын хөтөч гэсэн ангиудыг шинээр нээсэн байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн санхүүжилтийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийг 2016-2021 оноор жилээр харвал: *Хүснэгт № 23*

Он	Оюутны тоо		Санхүүжилт	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2017	460	422	1,159.0	1,137.7
2018	490	477	1,163.0	1,174.8
2019	480	416	1,333.1	1,308.6
2020	570	515	1,732.6	1,691.0
2021	575	553	1,590.2	1,572.4
Дүн	2925	2713	8063.8	7975.8

Хүснэгтээс харахад:

Политехникийн коллежийн суралцагсдын тоо өндөр байгаа нь 2.5 жилийн ангид элсэн суралцагчид тухайн ондоо төгсдөггүйтэй холбоотой байна.

Политехникийн коллеж нь 15-20 чиглэлээр 2017-2021 онд 1313 оюутны элсэлт авч 904 оюутныг төгсгөсөн байна.

Ажил эрхлэлтийн судалгааг суралцаж төгссөнөөс хойш 2 жилийн хугацаанд 6 болон 12 дахь сард төгсөгчдийнхөө дунд явуулдаг байна. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг харвал:



Графикаас харахад: МСҮТ-ийг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувийг харахад жил бүр нэмэгдэж байгаа нь мэргэжлийн боловсролын байгууллагын хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаа болон санхүүжилт үр нөлөөтэй байгааг харуулж байна.

2.5. Цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь иргэд, аж ахуйн нэгжид тодорхой дэмжлэг болсон байна.

Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт ХЭДС-аас 456.1 сая төгрөг зарцуулсан байна.

Аймгийн ХХҮГ-аас Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”-ийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийн төсвийн төлөвлөгөө гүйцэтгэл, хүрэх үр дүнг хүснэгтээр харуулбал: *Хүснэгт № 24*

№	Арга хэмжээ	Төсөв		Хүрэх үр дүн		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөсөн үр дүн	Хүрсэн түвшин	Хувь
1	Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг	210.0	210.0	42	45	93%
2	Аж ахуй эрхлэлтийн сургалт	5.4	5.4	180	180	100%
3	Малчин өрхийг малжуулах	115.0	113.0	23	24	96%
5	МАН эрхлэлтийн сургалт	6.9	6.9	58	132	44%
5	Нийтийг хамарсан ажил	98.0	83.6	350	312	112%
6	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ	30.0	30.0	5	6	83%
7	Борлуулалтын дэмжлэг	12.0	7.2	0	15	0%
	Нийт	477.3	456.1	658	714	92%

Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийн төлөвлөгөө гүйцэтгэлээс харахад үр дүнтэй хэрэгжсэн гэж дүгнэлээ.

Хөтөлбөрийн хүрээнд хийсэн сургалтуудыг ковид-ын нөхцөл байдлаас шалтгаалан цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.

Цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр 1,577.1 сая төгрөгийн хөнгөлөлт чөлөөлөлтийг үзүүлсэн байна.

УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолын дагуу цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. **Үүнд:**

- 2020.04.01-2020.10.01–ний хугацаанд цалин хөдөлмөрийн хөлсөнд ногдуулсан ХХОАТ-ыг 489 аж ахуйн нэгжийн 3511 иргэн хамрагдаж 703.5 сая төгрөгийн чөлөөлөлт эдэлсэн байна.
- Цар тахлын үед ажилтан болон ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг 2020 онд 3,261.3 сая төгрөг, 2021 онд 660.6 сая төгрөгийн чөлөөлөлтийг үзүүлсэн байна.
- Ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон 2020 оны 4-6 сард сар бүр 200.0/хоёр зуун/ мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Энэ арга хэмжээний хүрээнд Хөвсгөл аймагт 97 аж ахуйн нэгжийн давхардсан тоогоор 1066 даатгуулагч 213.0 сая төгрөгийн дэмжлэгийг авсан байна. Сар бүрээр нь харвал:



Ажилгүйдлийн даатгалын сангаас ажилтанд өгсөн дэмжлэгээс харахад сар бүр ажилтны тоо нэмэгдэж байгаа нь тухайн арга хэмжээ үр дүнтэй байсныг харуулж байна.

Цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалах чиглэлээр Монгол банкаар дамжуулан 3 хувийн хүүтэй зээлийг олгосон байна.

Эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөрийн хүрээнд Хөвсгөл аймагт ажлын байрыг дэмжих, хадгалах чиглэлээр 1644 иргэн, 91 аж ахуйн нэгжид нийт 55,705.3 сая төгрөгийн 3 хувийн хүүтэй зээлийг олгосон байна. Олгосон зээлийг хүснэгтээр харуулбал:

№	Зээлийн нэр, төрөл	Зээлдэгчийн тоо		Олгосон зээлийн хэмжээ	
		Иргэн	ААН	Иргэн	ААН
1	Ажлын байрыг дэмжих зээл	856	86	24,644.6	16,321.5
2	Газар, тариалангийн зээл	8	5	191.7	298.0
3	Малчдыг дэмжих зээл	780		14,249.4	-
	Нийт	1,644	91	39,085.7	16,619.5

Аймгийн Засаг даргын Тамгын газар болон ХХҮГ нь энэхүү зээл, зээлийн хүрээнд бий болсон болон хадгалагдсан ажлын байртай холбоотой тайлан, тоон мэдээлэлгүй байна.

Аудитын хугацаанд талбарт ажиллахад холбогдох мэргэжилтэнтэй хийсэн уулзалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах үед ажлын байрыг дэмжих зээлийг цар тахлын үед ажил олгогчдод нэмэртэй арга хэмжээ болсон гэж дүгнэж байсан.

Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлт, статистик тоо мэдээг гаргаагүй байна.

Цар тахлын дэгдэлттэй 2020, 2021 оны ажилгүйдлийн түвшин хөдөлмөр эрхлэлтийн түвшинг өмнөх онтой харьцуулан харахад дараах байдалтай байна.

№	Үзүүлэлт	2019	2020	2021
1	Ажилгүйдлийн түвшин	12.4%	8.9%	9.3%
2	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	60.8%	61.2%	60.4%

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ, НБХэлтэс

Коронавируст халдварын улмаас 2021 онд хөдөлмөр эрхлэлтийн түвшин буурсан боловч аймгийн ХХҮГ, Статистикийн хэлтэс бусад холбогдох газарт ковидын улмаас гарсан тоо хэмжээний өөрчлөлтийг харуулах мэдээллийн сан байхгүй байна. Мөн өөрчлөлтийг тооцохоор гарган нэгдсэн маягт судалгаа байхгүй байна.

Цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний Хүрэх үр дүн тодорхойгүй тул дүгнэлт өгөх боломж хязгаарлагдмал байна.

Аудитын хүрээнд авсан санал асуулгын үр дүн: Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэхээр олгож буй хөнгөлөлттэй зээл олголтын ил тод байдлыг тодруулахаар нийт 9 сумын 217 иргэнийг судалгаанд түүвэрлэн хамрууллаа. Судалгааны үр дүн дараах байдалтай байна. Дүрслэл №1

1. Хөдөлмөр эрхлэлтийн байдал

Төрийн алба – 25.8%
Хувийн хэвшилд – 7.8%
Тэтгэвэрт – 7.4%
Малчин – 4.1%
Хувиараа – 26.3%
Ажилгүй – 28.6%

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр болон хөнгөлөлттэй зээл /СХС, ЖДҮ, ХЭДС/-ийн талаар та мэдээлэл авч байсан уу?

Тийм – 61.9%
Үгүй – 38.1%

3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр болон хөнгөлөлттэй зээлд хамрагдах хэрэгцээ танд байгаа юу?

Тийм – 63.1%
Үгүй – 36.9%

4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл /СХС, ЖДҮ, ХЭДС/-д хамрагдаж байсан уу?

Тийм 9.7%
Үгүй 81.6%
Төсөл өгсөн боловч шалгараагүй 8.8%

5. Төсөл сонгон шалгаруулалт ил тод нээлттэй явагдаж байна уу?

Тийм 33.6%
Үгүй 66.4%

6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлийн мэдээллийг хаанаас авсан бэ?

Багийн Засаг дарга, хорооны ажилтнаас 42.9%
Орон нутгийн мэдээллийн самбараас 8.3%
Телевиз, сошиалаар /facebook/ 19.4%
Найз нөхөд, таньдаг хүмүүсээс сонссон 22.6%
Мэдээлэлгүй 6.9%

7. Сум орон нутгийн төрийн байгууллагаас хөдөлмөр эрхлэлт, ажлын байртай холбоотой төрийн үйлчилгээг хэрхэн үзүүлж байна вэ

Хангалттай 39.6%
Хангалтгүй 60.4%

Асуумжийн дүгнэлт:

1. Нийт санал асуулгад оролцогчдын 25.8 хувийг төрийн албанд ажиллагсад, 26.3 хувийг ХХЭ-д, 28.6 хувийг ажилгүй иргэд эзэлж байна.
2. Санал асуулгад оролцогчдын 61.9 хувь хөдөлмөр эрхлэлттэй холбоотой төсөл хөтөлбөрийн зээлийн мэдээллийг авсан байна.
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөнгөлөлттэй зээлд хамрагдах хэрэгцээ 63.1 хувьд нь байна.
4. Санал асуулгад оролцогчдын 81.6 хувь нь зээл, төсөл хөтөлбөрт хамрагдаж байгаагүй байна.
5. Төсөл хөтөлбөрийн шалгаруулалтыг 66.4 хувь нь ил тод явадггүй гэж үзжээ.
6. Төсөл хөтөлбөр, зээлтэй холбоотой мэдээллийг ихэнх иргэд баг хорооны засаг даргаас мэдээллээ авдаг гэж хариулжээ. Энэ нь Багийн дарга, хорооны ажилтан, зээлийн мэдээлэлд ойр буюу сумын ЗДТГ ажилладаг албан хаагчдын эргэн тойрны хүмүүс зээлд илүү хамрагдах боломжтой байгааг харуулж байна.
7. Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой төрийн байгууллагын үнэлгээг иргэдийн 60 хувь нь хангалтгүй гэж үнэлжээ.

ДҮГНЭЛТ

1. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр баримталж байгаа бодлого чиглэлийн хүрээнд аймаг орон нутгийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тодорхой зорилт, арга хэмжээг тусгаж, төлөвлөсөн боловч шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг батлаагүй, заасан хугацаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар шийдвэр гаргаагүй, үр дүнг тооцож ажиллаагүй, байгаагаас бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.
2. Холбогдох төрийн болон төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангаагүй, ХБИ иргэнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж байгууллагаас төлөх төлбөрийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн санд төвлөрүүлэх арга хэмжээг зохион байгуулаагүй, орон нутагт хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, үр нөлөөнд үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргаагүй, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн талаарх тоо мэдээллийг гаргуулан, үнэн бодит байдлыг хэлэлцээгүй зэргээс харахад аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь дүрэмд үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
3. ХЭДС, СХС, ЖДҮХС, ӨГҮДС, ҮДС-ийн хөрөнгөөр аймгийн хэмжээнд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хянаж үзэхэд бий болсон ажлын байрны талаарх нэгтгэсэн мэдээлэлгүй, тус сангуудын эх үүсвэрээр хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн зориулалт, үр дүнд хяналтыг бодитой хэрэгжүүлээгүй зэргээс харахад төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг бодитой тооцож чадаагүй байна.
4. Цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд нийгмийн даатгал, хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн, ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж, шаардлагатай иргэн аж ахуйн нэгжид жилийн 3 хувийн хүүтэй зээл олгосон зэрэг үйл ажиллагаа нь иргэн, аж ахуйн нэгжид тодорхой дэмжлэг болсон байна.
5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутагт хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийг зэрэгцүүлэн үзэхэд тухайн төсөл арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн дүн бага боловч тодорхой үр дүнд хүрсэн, нөгөө талаасаа санхүүгийн дэмжлэгийг өндөр дүнгээр авсан боловч үр ашиг өгөөгүй тохиолдол байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Г.Мөнгөнхуяг-т

1. Аймгийн ИТХ-аас 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр" болон аймгийн ИТХ- тогтоолоор батлагдсан дэд хөтөлбөрийн үр дүнг хэлэлцүүлж байх.
2. Аймгийн ИТХ-ын 2016 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам”-д заасны дагуу аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, сангийн үйл ажиллагааны тайланг жил бүр хэлэлцүүлж байх

Аймгийн Засаг дарга, аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн дарга Ш.Идэрбаясгалан-д

3. Аймгийн ИТХ-ын 2016 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн сан”-ийн журамд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах.
4. Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн хуралдаанаас гарсан тэмдэглэлийг тухай бүр гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж байх
5. Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан, өрхийн үйлдвэржилтийг дэмжих сан, Сум хөгжүүлэх сан, Жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд түр, шинээр бий болсон ажлын байрны талаарх мэдээллийг нэгтгэн, мэдээллийн сантай болох

Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунтуяа-д

6. Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангаас зээл олгох төсөл сонгон шалгаруулах комисс чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах.
7. Аймгийн үйлдвэржилтийг дэмжих сангийн үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэн тус сангийн мөнгөн хөрөнгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлэх асуудлыг шийдвэрлэх, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай бол үр дүнг тухай тооцож ажиллах

Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга Б.Эрдэнэхуяг-т

8. Орон нутгийн төсвөөс хуульд заасан хувь хэмжээгээр ХЭДС-ийн эх үүсвэрийг бүрдүүлэх хөрөнгийг тооцож аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлж ажиллах
9. ХБИ ажиллуулаагүйн төлбөрийг ХЭДС-д бүрэн төвлөрүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах
10. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүү дэмжлэг олгосон болон эргэн төлөлтийн мэдээллийг программд тухай бүр оруулж мэдээллийг шинэчлэх, программын мэдээлэлд тулгалт хийж хяналтыг хэрэгжүүлж ажиллах

Сумдын ИТХ-ын дарга нарт:

11. Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн, орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн, шийдвэрлэх.

ТАЙЛАНГААР ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

1. ХЭДС-ийн Санхүү дэмжлэгийн эргэн төлөлтийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулбал эргэн төлөлт сайжирч, тодорхой үр дүн гарахаар байна.
2. Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулийн 28.7⁶-д зааснаар аймгийн зөвлөлд аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга, ажилтныг оруулахыг хориглосон заалттай боловч Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 2 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрмийн 3.8⁷-д зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хөдөлмөрийн хэлтсийн дарга байхаар зохицуулсан байгаа нь хууль тогтоомжийн холбогдох заалтууд хоорондоо зөрчилдөөнтэй байна.

⁶ Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн гишүүнээр хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга, ажилтныг оруулахыг хориглоно.

⁷ ... Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтсийн дарга байна.

Зөрчлийн жагсаалт

№	Аудитаар илэрсэн Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /сая төг/	Өгсөн албан шаардлага		Төлбөрийн акт		Зөвлөмж	
			тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Аймгийн ИТХ-аас 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр" болон аймгийн ИТХ- тогтоолоор батлагдсан дэд хөтөлбөр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлээгүй байна.						1	0
2	“Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн тусгай сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам”-д заасны дагуу аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, сангийн үйл ажиллагааны тайланг жил бүр хэлэлцүүлээгүй байна.						1	0
3	Аймгийн ИТХ-ын 2016 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн сан”-ийн журамд заасан чиг үүргээ аймгийн Засаг дарга бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.						1	0
4	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн Зөвлөлийн хуралдаанаас гарсан тэмдэглэлүүд нь Зөвлөлийн даргын гарын үсэг зураагүй бөгөөд хүчин төгөлдөр бус дутуу байна.						1	0
5	Эрэмбэлсэн төсөлд зээл олгоогүй, төсөл ирүүлээгүй аж ахуй нэгжид зээл олгосон, зээлийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж олгосон, зээл олгохоор шийдвэрлэсэн хурлын тэмдэглэлийг бүрэн баталгаажуулаагүйгээс үзэхэд төсөл сонгон шалгаруулах комисс чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж						1	0
6	ХЭДС-д орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилуулахаар төсвийн төслийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлээгүй байна.						1	0
7	ХБИ ажиллуулаагүйн төлбөрийг бүрэн бүрдүүлээгүй байна.						1	0
8	Орон нутгийн тусгай сан буюу аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан, өрхийн үйлдвэржилтийг дэмжих сан Сум хөгжүүлэх сан, Жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд түр, шинээр бий болсон ажлын байрны талаарх мэдээллийг нэгтгэж, бүртгэл хөтлөөгүй байна.						1	0
9	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүү дэмжлэг олгосон болон эргэн төлөлтийн мэдээллийг программд мэдээллийг шинэчлээгүй.						1	0
10	Эрэмбэлсэн төсөлд зээл олгоогүй, төсөл ирүүлээгүй аж ахуй нэгжид зээл олгосон, зээлийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж олгосон, зээл олгохоор шийдвэрлэсэн хурлын тэмдэглэлийг бүрэн баталгаажуулаагүйгээс үзэхэд төсөл сонгон шалгаруулах комисс чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.						1	0

11	Сумын ИТХ, ИТХ-ын зээлийн хяналтын хорооноос Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хэрэгжилт, зарцуулалтад хяналт тавьж ажилладаг ч зээлийг зориулалт бусаар ашиглаж буйд тавих хяналт сул байна.						1	0
12	Аймгийн ХБТХОХ-ээс сангийн үйл ажиллагаа, зээлийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээг 2019, 2020, 2021 онуудад аймгийн ИТХ-д тайлагнаагүй бөгөөд 2018 онд гүйцэтгэсэн "Орон нутгийн хөрөнгийн эргэн төлөгдөх зээлийн сангуудын үйл ажиллагаа, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудит (ХӨА-2018/02/-ГА)-аар өгсөн "Сангийн үйл ажиллагаа, зээлийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнах." зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.		1	0				
13	Төрийн аудитын газраас 2018 онд гүйцэтгэсэн "Орон нутгийн хөрөнгийн эргэн төлөгдөх зээлийн сангуудын үйл ажиллагаа, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудит (ХӨА-2018/02/-ГА)-аар өгсөн "Сангийн хөрөнгөнд дотоод хяналт хийж, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд болон Засаг даргад танилцуулж байх" гэсэн зөвлөмжийг СХАА нь хэрэгжүүлээгүй байна		1	0				
14	Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн 2016-2021 оны тайлан болон хуралдааны тэмдэглэлээс үзэхэд дүрэмд заасан чиг үүргүүдээс доорх арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.		1	0				
15	ХЭДС-ийн санхүүгийн дэмжлэгийн хугацаа хэтэрсэн эргэн төлөлтийн үлдэгдэл 740.4 сая төгрөг байна		1	0	740.4			
Нийт дүн		740.4	4	0			13	0

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

67120. Хөвсгөл аймаг, Мөрөн сум
Нутгийн удирдлагын ордон 3 давхар. Утас: 7038 2764,
Факс: 7038 2554 Э-мэйл: aimginithural@khs.gov.mn
Вэбсайт: Khovsgol.Khural.mn

2022.05.05 № 02/192
танай 2022.05.05 -ны № 353 -Т

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР
ТАНАА

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас гүйцэтгэсэн “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангаар өгч буй зөвлөмжийг дэмжиж, хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах болно.

Тайлангийн
төсөлд санал
ирүүлээгүй.

НАРИЙН БИЙГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРДОН
ГҮЙЦЭТГЭГЧ Р.МАШБАТ



6712007020



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**

Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын байр

Утас, факс: 7038 4035

Цахим шуудан: info@khovsgol.khudulmur-halamj.gov.mn

Цахим хуудас: www.khovsgol.khudulmur-halamj.gov.mn

2022.05.05 № 194

танай 2022.05.05-ны № 351 -Т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**


Тайлангаар өгсөн зөвлөмж, албан
шаардлагыг хэрэгжүүлж ажиллана.

Тайланд тусгах саналгүй болно.

Тайлангийн
төсөлд санал
ирүүлээгүй.

ДАРГА

Б.ЭРДЭНЭХУЯГ



13014 137



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАЗАР**

Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/Факс: 7038 2577

Цахим шуудан: xhaagazar@khs.gov.mn

2022.05.05 № 1/206

танай 2022.05.05-ны № 350 -Т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх” чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт үр дүн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Цаашид тайлангийн дүгнэлтээр өгөгдсөн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллана.

Тайлангийн
төсөлд санал
ирүүлээгүй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Я.ЭРХЭМБАЯР



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА**

Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
АЗДТГ-ын байр А корпус 1 давхар, Утас: 7038 3934,
Цахим шуудан: sankhuu_audit_hu@yahoo.com

2022.05.05 № 1/93
танай _____ -ны/№ _____ -т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Тайлбар хүргүүлэх тухай

Танай “Орон нутгийн хөрнөгийн эргэн төлөгдөх зээлийн сангуудын үйл ажиллагаа, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийн бүртгэлтэй танилцлаа.

Манай байгууллага нь аймгийн “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих тусгай сан”-ийн үйл ажиллагаанд 2019 онд дотоод аудит хийж илэрсэн асуудалд хугацаатай зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын дүрэм, стандартаар тухайн жилд гүйцэтгэх аудитыг эрсдэлд суурилан төлөвлөн хэрэгжүүлдэг бөгөөд төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд үйл ажиллагаа явуулах үүрэгтэй тул тус сангуудын үйл ажиллагаанд жил бүр дотоод аудит хийх боломжгүй юм.

Мөн тухайн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн товч утгаас харахад ажил хариуцсан албан тушаалтны ажилдаа хариуцлагагүй хандсантай холбоотой зөрчил байна.

Иймд танай аудитаар илэрсэн зөрчил нь дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйгээс шалтгаалсан гэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.МӨНХТУЛГА

Тайлангийн төсөлд ирүүлсэн саналыг
тусгах боломжгүй байна.

671204032

Тайлангийн төсөлд Санхүүгийн, хяналт аудитын албанаас ирүүлсэн санал:

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд гүйцэтгэсэн "Орон нутгийн хөрөнгийн эргэн төлөгдөх зээлийн сангуудын үйл ажиллагаа, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийн мөрөөр 2019 онд дотоод аудит хийж илэрсэн зөрчлийг арилгасан.

Тайлангийн төсөлд ирүүлсэн саналд өгөх тайлбар:

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020, 2021 онд орон нутгийн тусгай сан “аймгийн үйлдвэржилтийг дэмжих сан, өрхийн үйлдвэржилтийг дэмжих сан”-д хяналт хэрэгжүүлээгүй тул ирүүлсэн саналыг хүлээн авах үндэслэлгүй байна.